

## **Монгол Улсын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын олон талт оролцогчдын уулзалтын тэмдэглэл**

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын Үндэсний зөвлөл, ажлын хэсэг, ажлын албаны хамтран зохион байгуулсан Монгол Улсын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын олон талт оролцогчдын уулзалт 2008 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 9 цаг 30 минутад Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн хурлын танхимд болов.

Уулзалтад ОУИТБС-ын үндэсний зөвлөл, ажлын хэсгийн гишүүдээс гадна, урилга өгсөн олон талт оролцогчдын төлөөлөл оролцов.

Олон талт уулзалтыг нээж Ерөнхий сайдын ахлах зөвлөх, ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга, Ажлын хэсгийн ахлагч Д.Батбаяр товч үг хэлж нээв.

Олон талт чуулга уулзалтаар дараахь асуудлыг танилцуулав:

1/Монгол Улсын 2006 оны анхдугаар тайланг гаргасан аудиторын компанийн тайлангийн Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмонгийн танилцуулга (Нэгдсэн тайлан болон танилцуулгыг бүрэн эхээр хавсаргав);

2/ОУИТБС-ын 2006 оны нэгдсэн тайланд гарсан зөрүүний талаар Сангийн яамны дүгнэлт-Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн газрын дарга Ж.Үхэртар (Дүгнэлтийг хавсрагав);

3/Тайлангийн талаархи олборлох үйлдвэрлэлийн компаниудаас өгөх дүгнэлт-Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал, Үндэсний зөвлөл, ажлын хэсгийн гишүүн Н.Алгаа;

4/Тайлангийн талаархи иргэний нийгмийн байгууллагын үнэлгээ-"Төлсөн Авснаа Нийтэл" иргэний нийгмийн эвслийн тэргүүн Батпүрэв.

Олон талт уулзалтын хөтөлбөрийн дагуу эхлээд ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон, дараа нь Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн газрын дарга Ж.Үхэртар Сангийн яамны дүгнэлтээ танилцуулав. Танилцуулга, дүгнэлтийг бүрэн эхээр хавсрагав.

Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал Н.Алгаа компаниудын тайланд хамрагдалт хангалттай байгаа, энэ санаачлага үр дүнгээ өгнө гэсэн итгэлтэй байна. Санаачлагын нэр маань олборлох үйлдвэрлэл шүү дээ, гэтэл хайгуулын компаниудыг ч хамруулж байгаа, цаашид эдгээр компанийг хамруулах эсэхийг судлах, тайлангийн маягтад улс, орон нутагт төлдөг бүх татвар, төлбөр, тэр битгий хэл үйлчилгээний хөлс, хураамжууд гээд их өргөн хүрээг хамарсан, гол нь олборлох үйлдвэрлэлийн онцлогтой холбоотой орлогын албан татвар, нөөцийн төлбөр, газрын төлбөр, усны төлбөр гээд гол гол татвар, төлбөрийг маягтад оруулах, гаалийн татвар, гаалийн хураамж гээд янз бүрийн эргэж шалгахад хүндрэлтэй татвар, төлбөрийг маягтаас хасах хэрэгтэй байна. Аудитын тайлангаар зөрүү гарсан 25.0 тэрбум төгрөгийг хайхаар бүртгэлтэй холбоотой асуудал гарч байна. Иймд

элдэв төрлийн хураамж, үйлчилгээний хөлс зэргийг тайлангийн сайн дурын гэсэн хэсэгт оруулах нь зүйтэй. Орон нутагт очиж байгаа төлбөрүүдийг орон нутагт нь шууд очдог болгох, тэнд нь нээлттэй болгох саналтай байна, аудит хийсэн компанийн нэг талаас төлсөн, нөгөө талаас авсан 2-ын зөрүү буюу энэ асуудал нь бүртгэл, мэдээллийг сайжруулах талаасаа ач холбогдолтой гэв.

Аудит хийсэн компанийг хэрхэн сонгосон, энэ нь зөв эсэх талаар оролцогчдоос асуусан асуултад Сангийн яамны газрын дарга Ж.Үхэртар хариулахдаа манай улсын дотоодын аудитын компани аудит хийсэн бол асуудлыг сайн тодорхойлж, зөрүүг олж чадна, ийм үндэслэл нь Дэлхийн банк буцалтгүй ОУИТБС-ыг дэмжин хөгжүүлэх зорилгоор тусламж өгч, олон улсын аудитын компани шалгаруулахыг шахаж, зөвлөлгөө өгч, түүний дагуу бид ажиллаж байгаа ч буцалтгүй тусламж нь Монгол Улсын төсвийн нэг хэсэг болон бүртгэгдэж, Монгол Улсын хуулиар зохицуулагдаж байгаа явдал юм гэсэн утгаар хариулав.

Тайлангийн талаархи иргэний нийгмийн байгууллагын үнэлгээ чиглэлээр "Төлсөн Авснаа Нийтэл" иргэний нийгмийн эвслийн тэргүүн Батпүрэв хийсэн мэдээлэлдээ тайлан буруу гаргасан компани, Засгийн газрын компанийг хуулийн дагуу арга хэмжээ авах, тайланд гарсан 25.0 тэрбум төгрөгийн зөрүүг Сангийн яам бүрэн дүүрэн дүгнээгүй байна. Тайлан гаргах цаг хугацааг хуулийн дагуу болгох, хугацаанд гаргахыг санал болгож байгаа нь буруу, тайланг хуулийн этгээд болгон нийтэд мэдээлж байх зэрэг асуудлыг хөндөж ярив.

Олон талт уулзалтын үеэр оролцогчдоос асуусан асуулт, түүнд өгсөн хариултыг энд нэг бүрчлэн тэмдэглэхийг зориогүй бөгөөд гол гол асуулт, түүнд өгсөн хариулт, оролцогчдоос гаргасан саналыг тэмдэглэлд тусгасан болно.

Петро Чайна компанийн Ерөнхийлөгчийн зөвлөх А.Эрдэнэдорж манай компанийн Засгийн газарт төлсөн 3.9 тэрбум төгрөгийг Засгийн газар тайлагнаагүй гэжээ. Гэтэл энэ асуудлыг Сангийн яамнаас саяны дүгнэлтээр авсан гэж байна. Энэ нь аудит хийсэн компани Засгийн газар, Сангийн яамнаас тодруулга хийгээгүй байна гэсэн үг. Энэ дунд компани "хүнд байдал"-д орж байгаа юм. Мөн манай компанийн зөрүүнд яам, агентлагт өгсөн мөнгөн тусламж оржээ. Хандив, тусламжийн асуудал ямар ч хуулийн байхгүй мөртлөө, хориотой мөртлөө газар дээрээ байдал өөр байна. Дорнод аймгийн Засаг дарга манай газар нутаг дээр үйл ажиллагаа явуулж байгаа нэрээр 1 тэрбум төгрөгийн хандив нэхэж байна. Ер нь төрийн захиргааны байгууллага хандив, тусламж хуулиар авахыг хориглох хэрэгтэй байна. Гаднын компанийн хийсэн аудитын дүгнэлтийг маш сайн нягталж дүгнэх хэрэгтэй байна гэж тэрээр хэлэв.

Багануур ХК-ийн захирал Дамбапэлжээ тайлангаас харвал Багануур компанийн тайлангаас Засгийн газрын тайлан илүү байгаа нь зөрүүг компани буцааж авч болно гэсэн үг үү.

Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын мэргэжилтэн Цэгц хариулахдаа тайлан дээр Алтан дорнод монгол ХХК нөөцийн төлбөр 20 гаруй мянган ам.доллар илүү төлсөн мэтээр тулгалт дээр гарчээ. Төлбөр хийсэн баримт 3 хувь хийгдэж, 1 хувь нь банкинд, 1 хувь нь АМГТХЭГ-ын санхүүд, 1 хувь нь

кадастрийн албанд очдогоос өөрт нь хувь үлддэггүй учир компани таамгаар мэдээ гаргасан байна.

Сангийн яамны мэргэжилтэн Ундраа Байгаль орчны яамнаас энд хүн алга байна, маягт дээр байгаль хамгаалах санд хуримтлуусан хөрөнгө сайн дурын гэсэн хэсэгт байгаа, иймд тайланд тоо тавигдахгүй байгаа тул заавал гаргах гэсэн хэсэгт оруулах хэрэгтэй байна.

Үндэсний татварын ерөнхий газрын мэргэжилтэн Шатар бид 2006 оны тайланг ярьж байна. Тайлан гаргаж байгаа нь үр дүн өгч байнаа, гэвч хүндрэл их байнаа, маягт дотор татварын байгууллагын чиг үүрэгт хамаарахгүй, манай байгууллага хүчрэхгүй үзүүлэлт явж байгаа. Иймд 2007 оны тайлангийн өмнө маягтаа сайжруулах хэрэгтэй байна. Орон нутгийн Засаг дарга нараас авах мэдээнд анхаарах, тухайлбал, Эрдэнэт, Төв аймаг 2-ын газрын төлбөр нь газрын албаны тайланд явдаг, манайд мэдээ ирдэггүй. 25.0 тэрбумын зөрүүг олох асуудлыг 1 өнцгөөс харж байгаа нь сайн зүйл. Ил тод байдал зарчмыг төсвийн бүх дансанд хийх явдал чухал. Хандивын мэдээ гаргахад аль шатны татварын байцаагч нар мэддэггүй, хамгийн "дампуу" асуудал энэ байна. Хуультай татвар, төлбөрийг хуулийнх нь дагуу өгч мэдээлэх, хууль тогтоомжгүй асуудлыг мэдээлэхгүй байх зарчмыг л дагаж байна. Юуг хаа төлөх, хэн мэдээлэх нь тодорхой байх ёстой. Тайлангийн маягтад "бусад" гэдэг "хогийн сав" бий, энд тавьсан тоо яаж задарч болдоггүй. Бид 2006 оны тайлан ярьж байгаа ч гол асуудал нь оны дуусах 12 дугаар сарын 31-ний шөнөөс өмнө мэдээг ярих ёстой. Энэ мэдээг оны эхний I улиралд гаргаж ярих ёстой. Гэтэл бид одоо ярьж байна. 2007 оны тайлангаас өмнө маягтыг хөнгөвчлөх хэрэгтэй байна. Маягтын хүснэгт бүр тоо нэхээд байгаа, хаана ямар тоо тавих вэ гэдэг нь хэнд тодорхой байх ёстой. Үүний зэргэцээ яаж зарцуулсныг ч нэхэх ёстой. Татварын одоо мөрдөж байгаа мэдээгээр татвар дүнгээрээ л ирж байгаа, үүнээс болоод татвар хооронд зөрүү гараад байна. Бид нийгэмд үйлчилж байна гээд буруу мэдээ гаргаж төр, компани 2-ыг унагах вэ гэдэг ойлголт төрөөд байна. Татварын мэдээ, мэдээллийн сүлжээ 2-ыг эмхэлж цэгцлэх шаардлагатай байна. Үүнээс гадна ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулгын тусгай зөвшөөрөл, орд бүрийн нөөц, орд бүрийн металлын агуулгыг ил тод болгох хэрэгтэй байна. Энэ нь ОУИТБС-ын ил тод байдлыг хангахад хэрэгтэй байна.

Шивээ-Овоо компаниас оролцож төлөөлөл аль ч шатны шалгалтын үр дүн нь улс оронд ч, компанид ч ашигтай байх ёстой, Шивээ-Овоод гэхэд нийгмийн асуудал хоцорч байна, одоогийн ханшаар 1 кг нүүрс 8.5 төгрөг, 1 тонн нь 8500 төгрөг байна, гэтэл 1 хайрцаг шүдэнз 30 төгрөг байна, үүнээс болоод компани ямар ч ашиггүй ажиллаж байна. Манай компанид 1 хүний дундаж цалин 249 мянган төгрөг байна, манай салбарт 60 хүрч тэтгэвэрт гардаг хүн хэд билээ, энэ бодох асуудал болоод байна. Нэгэн судалгаагаар Налайхын уурхайд 18 жил ажилласан 650 хүнээс 21 нь 60 хүрч тэтгэвэрт гарсан байна. Одоогийн байдлаар Шивээ-Овоогийн уурхайд ажиллагсдын дундаж наслалт 53.7 жил байна, иймд компанийн санхүүгийн үзүүлэлтийг ил тод болгохын зэрэгцээ нэгж бүтээгдэхүүний үнэ, нийгмийн асуудалд анхаарах хэрэгтэй байна гэж хэлэв.

Монгол газар ХХК-ийн өлөөлөл хэлэхдээ туул уурхайн компаниуд улсад мөнгө төлдөггүй гэж иргэний хөдөлгөөнийхэн шүүмжилдэг, түүгээр үл барам компанийн эзэмшиж байгаа тусгай зөвшөөрлийг ч цуцлуулж байна. Үүнийг ер нь ойлгохоо

байлаа, уул уурхайн үйлдвэрлэлийг хориглох санаа тэдэнд байгаа юм уу. Манай компани гэхэд 1300 гаруй ажилагсадтай, ажиллагсад аа төдийгүй, тэдний ар гэрийг компани тэжээж байна, дээр нь улсад татвар, төлбөрөө төлж нийгэмд үүргээ гүйцэтгэж байна гэв.

Ерөнхий сайдын ахлах зөвлөх, Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга, ажлын хэсгийн ахлагч Д.Батбаяр олон талт уулзалтыг хааж хэлэхдээ олон талт оролцогч нарын энэ удаагийн уулзалт нь ОУИТБС-ын анхны тайлангаа танилцуулсан, түүнд оролцогч талууд үнэлгээ өгсөн, цаашид анхаарах асуудлыг талаар ярилцсан, ер нь нээлттэй, саналаа чөлөөтэй илэрхийлсэн нөхцөлд амжилттай боллоо гэж дүгнэж, олон талт уулзалтыг хаав.

Эцэст нь олон талт уулзалтад оролцогчдод талархал илэрхийлэв.

Товч тэмдэглэл хөтөлсөн:

Ажлын албаны ажилтан

Т.Хүрэлчимэг

Танилцсан:

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга

Э.Сумъяа